



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А173

Хажуу шинэ-Ус

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.4, 48.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.3 дахь хэсэг, 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Дэнжийн гудамжнуудыг өнгөт, гэрэлтүүлэгтэй болгох” ажил 94,451,297.00 (Ерэн дөрвөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга хоёр зуун ерэн долоо) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Смарт контрол” ХХК шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. Дэнжийн гудамжнуудыг өнгөт, гэрэлтүүлэгтэй болгох ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг “Смарт контрол” ХХК-д даалгасугай.

3. “Смарт контрол” ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401078